



УВС АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛД ХЯНАЛТ ХИЙСЭН
ТУХАЙ ДҮГНЭЛТ

2022 оны 07 сарын 18 өдөр

Дугаар 19

Улаангом

“ЭРХЭС КОНСТРАКШН” ХХК-НИЙ
ЗАХИРАЛ Л.ЭНХЦАЦРАЛТ ТАНАА

Нэг. Барилга байгууламжийн зураг төслийн мэдээлэл

1. Барилга байгууламжийн байршил: Зүүнхангай сум
2. Зургийн шифр, зураг төслийн компани: ЭК-56/2022-03
3. Барилга байгууламжийн зориулалт: Зүүнхангай сумын Хайрхан багт байрлах соёлын төвийн барилгын их засвар
4. Барилга байгууламжийн багтаамж, куб.м: 1080 м³
5. Барилгын байгууламжийн давхар, талбай: 486 м²
6. Галд тэсвэршилтийн зэрэг: төлөвлөсөн: 2 зэрэглэл
7. Үйлдвэрийн ангилал:
8. Барилгын үүргийн галын аюулын анги:
9. Зургийн иж бүрдэл:
10. Галын аюулгүй байдлыг хангах чиглэлээр:
 - 10.1. Гал унтраах автомат тоног төхөөрөмж: хуудас дугаар
 - 10.2. Галын дохиоллын зураг: хуудас дугаар
 - 10.3. Гал унтраах гадна усан хангамж: хуудас дугаар


Хоёр. Барилга байгууламжийн зураг төслийн галын аюулгүй байдалд хяналт шалгалт хийсэн тухай тэмдэглэл

№	Хяналт шалгалт хийсэн тэмдэглэл	Илэрсэн зөрчил	Стандарт норм норматив зөрчигдсөн заалт	Биелэлт
1	Ерөнхий төлөвлөгөө, галын аюулгүйн зай хэмжээ	Барилга хоорондын зай		+
		Галын автомашины зам		+
		Үер усны хамгаалалт		+
2	Архитектур төлөвлөлт, байгуулалт, хийц бүтээцийн шийдэл,	Барилгын материал		+
		Гадна шат		+
		Дотор шат, шатны хонгил, цахилгаан шат		
		Галаас хамгаалах хаалт, хаалга		
		Галаас тусгаарлах зааг, өрөө тасалгаа		+
		Дээвэр		+
		Газар доорхи давхрын, зориулалт		
	Авралтын зам, гарц		+	

8522340088

3	Гал түймрээс хамгаалах техник, тоног төхөөрөмж	Гал унтраах автомат тоног төхөөрөмж		+
		Гал гарсан тухай зарлан мэдээлэх систем		
		Галын дохиололын систем /утаа, дулааны мэдээлэгч/		+
4	Гал унтраах усан хангамж	Гадна усан хангамж		+
		Дотор усан хангамж		+
		Галын усан сан		
5	Агааржуулалт, утаа зайлуулах систем	Утаа зайлуулах		+
		Агаар өгөх		+
6	Цахилгааны ерөнхий сүлжээ, цахилгаан хэрэгсэл	Цахилгаан утасны сонголт		+
		Цахилгаан тоног төхөөрөмжийн сонголт		+
		Хуваарлах самбар		+
		Галаас хамгаалах төхөөрөмж		
		Зам гарцын гэрлэн тэмдэг, тэмдэглэгээ		+
		Ослын цахилгааны эх үүсвэр		+
		Аянга зайлуулагч, газардуулга		+
7	Тусгай шаардлага	1.		
		2.		
		3.		

Гурав. Ерөнхий дүгнэлт

Зөвшөөрсөн сар, өдөр	Зөвшөөрлийн тэмдэг дарсан хуудасны дугаарууд	Нэмэлт тэмдэглэл
2022 оны 07 сар 19 өдөр	Нүүр хуудас	
20... ОНЫ ...-Р САРЫН ... НИЙ ӨДӨР ГАРЫН ҮСЭГ:		

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

УВС АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
 ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ
 АХЛАХ ДЭСЛЭГЧ



Л.БАТБАЯР



УВС АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165
Утас/Факс: 7045-2524

Цахим шуудан: p_uv@inspection.gov.mn
Цахим хуудас: uvs.inspection.gov.mn/

2022.07.22 № 20-03-048/388

танай _____ -ны № _____ -т

Барилгын ажлын зурагт хяналт
хийсэн тухай

Увс аймгийн Зүүнхангай сумын Соёлын төвийн их засварын ажлын зураг төслийг боловсруулж байгаа ЭРХЭС КОНСТРАКШН ХХК-ийн албан хүсэлтийн дагуу ажлын зурагт “Эрүүл ахуйн тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасныг үндэслэн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт хийлээ.

Нэг. Барилга байгууламжийн зориулалт:

Увс аймгийн Зүүнхангай сумын Соёлын төвийн их засварын ажлын зураг нь төлөвлөж буй барилга архитектор, халаалт агаар сэлгэлт, дулаан механик, хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг, холбоо дохиолол гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Тус барилга нь 2 давхар, тэнхлэгээрээ 27x18 хэмжээтэй, төмөр бетон карказан бүтээцтэй. Зургийн Шифр: ЭК-56/2022-03. Уг барилгын 1-р давхарт байгаа нийт өрөөнүүдээс зуухны өрөөг узелийн өрөө, галчийн өрөөг цахилгааны өрөө болгож, соёлын заалыг одоо байгаагаас томруулж шинээр үзвэрийн кабинет, өлгүүрийн өрөөг төлөвлөсөн байна. Соёлын заал, дээрээ лонжтой байх, байгалийн гэрлийг коридорт тусгахын тулд ажилчидын өрөөний ханыг шилэн байхаар төлөвлөжээ.

Барилгын 1-р давхарт 7.63м³ хана буулгаж, 13.19 м³ ханыг ердийн улаан тоосгоор өрөх ба 2-р давхарт 12.6 м³ хана буулгаж, 4.54 м³ ханыг ердийн улаан тоосгоор өрхөөр тусгасан ба дээврийг шуувуун нуруун дээвэр байхаар тусгажээ. Ажлын даалгаварт тусгасны дагуу 36 ширхэг цонх, 25 ширхэг хаалгыг сольхоор төлөвлөсөн байна.

Халаалт, агаар сэлгэлтийн байдал: Тус барилгын халаалтын систем нь 2 хоолойт систем бөгөөд доороос түгээлттэй, мухардмал эргэлттэй системтэй байхаар төлөвлөсөн ба халаалтын системд Орос улсад үйлдэрлэсэн М140-АО маркын ширмэн радиатор угсрахаар төлөвлөсөн байна.

Тус барилгын агаар сэлгэлтийн системийг механик /соёлын заал/ болон ердийн агаар сэлгэлтийн системтэй байхаар төлөвлөсөн байна. Агаар сэлгэлтийн

8522060799

хоолойнуудыг 25мм-ээс багагүй дулаалгаар дулаалж галд тэсвэртэй туузаар бүрэхээр төлөвлөжээ.

Дулаан механик: Барилгын халаалтын эх үүсвэр цахилгаан зуух ба хүчин чадал нь 90 квт /DAKON төвийн ПТЕ -45 маркийн 2 ширхэг зуух/. Тус сумын сумын төв дээрх ус нь хатуулагийн үзүүлэлт шаардлага хангахгүй гардаг тул зөөлрүүлэх төхөөрөмж төлөвлөх нь зүйтэй.

Цахилгаан хангамжийн байдал: Цахилгаан найдвартай ажиллагааны 2-р зэргийн хэрэглэгч. ЕОС-1 самбарыг бие биеэсээ үл хамаарах хос кабель шугамаар, ОХС-1 самбарыг генератораас болон хос кабель шугамаар тэжээхээр төлөвлөсөн байна. Хүчний цахилгаан хэрэглэгчид болон самбарууд, розетка, салхивч болон сантехникийн тоног төхөөрөмж, гал эсэргүүцэх төхөөрөмж, тайзны гэрэл өргөх, буулгах хөдөлгүүр, хөшигний хөдөлгүүрүүд орох ба дотор гэрэлтүүлэгүүд /люминесцент, LED, улайсах гэрэлтүүлэгч/, газардуулга, аянга хамгаалалт зэргийг төлөвлөсөн байна.

Мэдээлэл, холбооны сүлжээний байдал:

Суурин телефон, интернетийн сүлжээ, зарлан мэдээллийн систем, галын дохиолол, теле-хяналтын систем, газардуулгыг тус тус төлөвлөсөн байна.

Хоёр. Захиалагчийн нэр, хэзээ, хаана баригдах:

Увс аймгийн Зүүнхангай сумын Хайрхан багт байрлах 200 суудалтай Соёлын төвийн их засварын ажлын зураг. Зургийн даалгаварыг соёлын төвийн эрхлэгч Ц.Цогтсайхан нар боловсруулж, Сумын Засаг дарга Б.Батсайхан гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан байна. Зургийн нүүр хуудсанд захиалагчаар Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газрын дарга О.Цэрэндорж гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан, зөвшөөрөлцсөн хэсэгт Увс аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Б.Баттулга гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан байна.

Дүгнэлт

Увс аймгийн Зүүнхангай сумын 200 суудалтай Соёлын төвийн их засварын ажлын зургийг хянасан зураг төслийн дагуу барихад эрүүл ахуйн талаас татгалзах зүйлгүй болно.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ



Б.ГАНЧИМЭГ